

ОЛОН УЛСЫН ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖИЛД БАНКНЫ ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Г.Бурмаа*, Б.Баярмаа, Д.Мөнх-Эрдэнэ**

Хураангуй: Олон улсын даатгалын зах зээлийн хөгжлийн үе шатууд, түүнд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлсүүдийг судалсны үндсэн дээр даатгалын зах зээлийн хөгжилд банкны даатгалын зуучлалын гүйцэтгэх үүргийг тодорхойлсон.

Олон улсын даатгалын зах зээл дээрхи банкны даатгалын зуучлалын өнөөгийн байдлыг Ази, Европын орнуудын хувьд сонгон судалж, банкны даатгалын зуучлалын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон.

Банкны даатгалын зуучлалын олон улсын туршлагыг судалсны үндсэн дээр Монгол Улсад банкны даатгалын үйл ажиллагааг өргөжүүлэх арга замыг тодорхойлсон болно.

Түлхүүр үгс: Банкны даатгалын зуучлал, амьдралын даатгалын, амьдралын бус даатгал, даатгалын нэвтрэлт, зардлын харьцаа

Topic: International insurance market and future trends of bancassurance

Abstract: In this work, we examined the role of banking insurance intermediaries in the development of the insurance market, based on development stages of the international insurance market and its internal and external factors that is affecting them.

We defined the current situation of banking intermediation in the international insurance market for selected some Asian and European countries and the trends of banking insurance intermediation development.

Based on the international experience in banking insurance intermediation, we have identified ways to expand banking insurance activities in Mongolia.

Keywords: Bancassurance, life insurance, non life insurance, penetration, expense ratio

* МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail) fin_burmaa@yahoo.com

**МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail) b_b_maa@yahoo.com, munkherdene_d@yahoo.com

Үндсэн хэсэг

Дэлхий дахинд санхүүгийн зах зээлийн глобалчлал, шинэ технологийн хөгжил, банкны үйл ажиллагааг харилцагчдад хүргэх түгээлтийн сувгийн өөрчлөлт, банкны бус санхүүгийн байгууллагуудын төрөлжилт зэргээс хамааран банкны бизнес тасралтгүй өөрчлөгдөж байна. Эдгээр өөрчлөлтөөс шалтгаалан санхүүгийн үйлчилгээний өөр хоорондоо ялгагдах хил хязгаар алга болж, шинэ ойлголтыг / концепци/ бий болгож, улмаар санхүүгийн үйлчилгээний нэгдмэл байдал үүсэж байна. Үүний нэг нь Bancassurance (Банкашуранс) буюу банкны даатгалын зуучлалын үйлчилгээ юм.

“Bancassurance” гэж олон улсад нэршил болсон энэхүү бүтээгдэхүүн нь “Банк” ба “Даатгал” гэсэн нэр томъёоны нийлбэр буюу banc + assurance. Банкны түгээлтийн сувгуудаар дамжуулан даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах зорилгоор 1980 онд Францад анх үүссэн. [10] Улмаар Европд маш хурдан нэвтэрч өнөөдөр даатгалын бизнесийн гол эх үүсвэр нь болж байна. [9]

Судлаачид банкны даатгалыг олон янзаар тодорхойлсон байна. Тухайлбал: Банкашуранс нь банкны харилцагчийн харилцаа холбоог ашиглан амьдралын болон амьдралын бус даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах үйл явц бөгөөд даатгалын бүтээгдэхүүнийг үр дүнтэй хөгжүүлэх даатгалын хөгжлийн зам гэж тодорхойлжээ. [6]

Банкашуранс нь энгийнээр банкаас даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах явдал юм. Энэ зохицуулалтанд даатгалын компани банкинд хандаж, даатгалын бүтээгдэхүүнээ өөрийн харилцагч нартаа борлуулах боломжийг олгодог. Энэ систем нь даатгалын компани банкны үйл ажиллагаагаар дамжуулан даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах боломжийг бий болгоно.

Банкашуранс нь даатгалын компани бүтээгдэхүүнээ банктай гэрээ байгуулсны үндсэн дээр худалдан борлуулах улмаар хүүгийн бус орлого олох эх үүсвэр юм. [2]

АНУ-д 1933 онд батлагдсан “Glass-Steagall” хуулиар банк, банкны бус санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг хориглож байсан бөгөөд энэ хуулийг 1999 цуцалж “Gramm-Leach-Bliley” хуулийг баталсанаар банкууд банкашуранс үйлчилгээ нь хууль ёсны болж шинэ ойлголтыг бий болгосон байна. [8]

Даатгалын салбарын хөгжлийг дөрвөн үе шатанд хуваах бөгөөд үе шат бүрт нөлөөлөх гадаад, дотоод орчны нөлөөлөл ялгаатай байдаг байна. Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас /OECD/ тодорхойлсон хөгжлийн үе шатны тодорхойлолтоор манай улс хөгжлийн эхэн шатанд хамаарагдаж байна.

Хүснэгт 1. Даатгалын хөгжлийн үе шат, түүнд нөлөөлөх хүчин зүйлс

Даатгалын хөгжлийн үе шат	Даатгалын зах зээлийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл	
	Гадаад хүчин зүйлс	Дотоод хүчин зүйлс
Үүсэн бий болох шат /Афганистан, Ирак/	<ul style="list-style-type: none"> Улс төрийн тогтвортой байдал Хүний эрх, өмчлөх эрхийн хамгаалал Хууль эрх зүйн орчин 	<ul style="list-style-type: none"> Даатгалын эрх зүйн орчин Зохицуулалт Хяналтын орчин Суурь мэдээллийн сан Засаглал, эрсдэлийн удирдлага Тайлагналын ил тод байдал
Хөгжлийн эхэн шат /Боливи, Египет, Монгол/	<ul style="list-style-type: none"> Орлогын түвшин Эдийн засгийн тогтвортой байдал Зах зээлд орох, гарах хязгаарлалт, өрсөлдөөн 	<ul style="list-style-type: none"> Олон улсын даатгалын хяналтын байгууллагын холбооны /IAIS/суурь зарчмууд Хэрэглэгчийн эрсдэлд хандах хандлага Актуарын тооцоолол Мэдээллийн сан Олон нийтийн санхүүгийн боловсрол Зах зээлийн хязгаарлалт Даатгуулагчийг хамгаалах тогтолцоо Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа Ёс зүйн хэм хэмжээ
Эрчимтэй хөгжиж буй шат /Энэтхэг, Хятад/	<ul style="list-style-type: none"> Орлогын түвшин Хадгаламжийн түвшин Санхүүгийн зах зээлийн хөгжил Хариуцлагын тогтолцоо Шүүхийн хараат бус байдал 	<ul style="list-style-type: none"> Зах зээлийн хязгаарлалт Даатгуулагчийг хамгаалах тогтолцоо Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа Ёс зүйн хэм хэмжээ
Хөгжингүй зах зээлтэй орнууд /АНУ, Европын орнууд/	<ul style="list-style-type: none"> Татварын бодлого 	<ul style="list-style-type: none"> Альтернатив эрсдэлийн болон санхүүгийн удирдлага Зах зээлийн эрсдэл

Эх сурвалж: Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын мэдээлэл

Хөгжлийн эхэн шатанд хөгжиж буй орнуудад нийтлэг тулгарч буй гол асуудлууд нь орлогын түвшин, ард иргэдийн санхүүгийн мэдлэг доогуур байгаатай холбоотой даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг сонгох, хэрэглэх, сонирхол бага, даатгалын хураамжийн орлого, нийт активын хэмжээ банкны салбартай харьцуулахад төдийлөн өндөр биш байна. Эдийн засгийн нөхцөл байдал болох инфляци, гадаад валютын ханшийн савалгаа өндөр, мөн хөрөнгийн зах зээл хөгжөөгүйтэй холбоотой даатгалын компаниуд нөөц сангуудаар дамжуулан хөрөнгө оруулалт хийхэд томоохон эрсдэлтэй тулгардаг төдийгүй даатгалын салбарт цөөн тооны томоохон компаниуд зах зээлийн ихэнхи хувийг

эзэлдэг нь жижиг, дунд аж ахуйн нэгжүүд уг салбарт үйл ажиллагаа явуулахад бэрхшээл тулгардаг байна.

Банкны даатгалын зуучлалын үйлчилгээний хөгжлийн эхэн шатанд тухайн улсын даатгалын үйл ажиллагааг зохицуулагч байгууллагын бодлогын арга хэрэгсэл оновчтой бус байгаагаас зах зээлийн зохицуулалт, хяналт нь дүрэм, журамд суурилсан шинжийг агуулсан, дэд бүтцийн ач холбогдол бүхий зуучлагчийн тогтолцоо болон андеррайтер, актуар хөгжөөгүй байдаг. Олон улсын даатгалын зохицуулалт, хяналтын байгууллагуудын холбооноос /IAIS/ хөгжиж буй орны зохицуулагч байгууллагад дараах зөвлөмжийг өгсөн байна.


Үүнд:

- Даатгалын салбарт эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоог нэвтрүүлж, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох
- Нэгдсэн мэдээллийн санг үүсгэх, баяжуулах, ашиглах /мэргэжлийн оролцогчдоос мэдээлэл авах, харилцан солилцох нөхцлийг бүрдүүлэх/
- Андеррайтерийн болон актуарын боловсон хүчнийг бэлтгэх
- Олон нийтийн даатгалын суурь мэдлэгийг дээшлүүлэх


Үүнээс дүгнэхэд дэлхий дахинд банкны даатгалын үйлчилгээ нь тухайн улсын хүн ам зүй, эдийн засаг, хууль эрхзүй зэргээс шалтгаалан хөгжлийн түвшин харилцан адилгүй, өөр өөр хэлбэрээр хөгжиж байна. Ойрын ирээдүйд ч банк болон даатгалын компаниудад харилцан ашигтай, даатгалын бүтээгдхүүний хуваарилалтын хамгийн үр дүнтэй, үр ашигтай арга болсоор байна. Дэлхий дахинд банкуудаас хуримтлуулсан даатгалын шимтгэлийн орлого санхүүгийн зах зээлд зохистой байдлаар нэмэгдэж, тухайлбал Европ, Латин Америк, Ази, Австрали зэрэг улсуудад үр дүнтэй хуваарилалтын суваг болж чадсан байна. Банкны даатгалын зуучлалын үйлчилгээ нь Европын банкууд болох Credit Agricole (Франц), ABN Amro (Нидерланд), BNP Paribas (Франц), ING (Нидерланд) зэрэг дэлхийн томоохон банкуудын зах зээлд давамгайлж байна. Банкны даатгалын зуучлал нь дэлхийн улс орон бүрд харилцан адилгүй хөгжиж буй бөгөөд 2006 оноос эхлэн Ази, Европын орнуудад маш үсрэнгүй хөгжиж эхэллээ.

Банкны даатгалын нэвтрэлт, хэрэгжилтийг дэлхийн хэмжээнд дүгнэх боломжгүй, учир нь нэвтрэлт нь улс бүрт ялгаатай байгаа юм.

Зураг 1. Амьдралын даатгалд банкны даатгалын зуучлалын эзлэх хувь



Зураг 2. Амьдралын бус даатгалд даатгалын зуучлалын эзлэх хувь



Эх сурвалж: Finaccord Global Bancassurance reports (Finaccord, 2016)


Зургаас харахад амьдралын даатгалд банкны даатгалын зуучлал Европын орнууд болох Испани, Франц, Итали зэрэг орнууд хамгийн багадаа 60-80% байгаа бол Азийн орнуудаас Солонгос, Хонконг, Индонез, Хятад, Тайвань зэрэг орнууд 40-60%, Америк тивийн улсууд буюу Бразил, Мексикт амьдралын даатгалын бүтээгдэхүүнд банкны даатгалын зуучлал өндөр байна.

Харин дэлхий дахинд амьдралын бус даатгалын борлуултанд банкны оролцоо амьдралын даатгалтай харьцуулахад бага буюу 40%-с доош хувийг бүрдүүлжээ. Амьдралын бус даатгалд банкны даатгалын зуучлал Азийн орнууд болох Индонез, Солонгос, Тайвань, Хонконг рейтинг өндөртэй байна.

Өөрөөр хэлбэл банкны даатгал нь олон улсад амьдралын даатгалын

зах зээлд түлхүү хөгжсөн байна. Иймд амьдралын даатгалд эзлэх банкны даатгалын оролцоог бүс нутгаар авч дараах зурагт үзүүлэв.


Зураг 3. Европын орнуудын амьдралын даатгалд банкны даатгалын эзлэх хувь (Хураамжийн орлогоор, 2014)



Эх сурвалж:Европын даатгалын хөгжил, 2015(Insurance, 2016)

Европын амьдралын даатгалын зах зээлийн ихэнх бүтээгдэхүүнийг банкны даатгалаар борлуулсан улсуудад Итали (нийт хураамжийн орлогын 79%) болон Франц (64%), Испани (63%) байна. Харин Их Британи, Германд амьдарлын даатгал агентуудаар түрхүү борлогдсон байна. Өөрөөр хэлбэл Европт банкны зуучлал нь борлуулалтын гол суваг нь болж байна.

Зураг 4. Азийн орнуудын амьдралын даатгалд банкны зуучлалын эзлэх хувь (Хураамжийн орлогоор, 2014)



Эх сурвалж: World insurance in 2015

Зураг-4 дээр Азийн орнуудын амьдралын даатгалд эзлэх банкны даатгалын зуучлалын эзлэх хувийг борлуулалтын сувгаар харуулахад дундажаар банкууд 42,2%, агентууд 44,2% байна. Турк, Тайвань, Өмнөд Солонгос, Хонконгзэрэг улсад банкны зуучлал нь амьдралын даатгалын зах зээлийн дийлэнх хувийг эзэлж байгаа бол Тайланд, Хятад, Малайз, Филиппин, Сингапур, Индонез зэрэг улсад банкууд болон агентуудын эзлэх хувийн жин ойролцоо түвшинтэй, зах зээлд өрсөлддөг болох нь харагдаж байна. Харин Энэтхэг, Шри Ланка, Вьетнам зэрэг орнуудад агентууд борлуулалтын хувь хэмжээгээр тэргүүлж байна.

Байгууллагын хөрөнгийн байдал, эрсдэлд хандах хандлага зэргээс хамааран банкны даатгалын хөрөнгийн үйл ажиллагааны загварууд өөр байх бөгөөд тэдгээрийн хөрөнгө, эрсдэл, ашгийн үзүүлэлт ч ялгаатай байдаг. Европын өндөр хөгжсөн зах зээлд цэвэр борлуулалтын загвараас дараагийн шат руу шилжиж стратегийн холбоо тогтоох, эсвэл хамтарсан хөрөнгө оруулалт хийж их борлуулалттай, хүлээх эрсдэл харьцангуй өндөртэй ч илүү ашигтай, бага зардалтай байх аргаар үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 2. Хөгжингүй орнуудад ашиглаж буй банкны даатгалын үйл ажиллагааны загварууд


Бизнес загвар	Хөгжингүй улс орнууд
Цэвэр борлуулалт/ distribution only/	Америк, Герман, Их Британи, Япон, Солонгос
Хамтарсан хөрөнгө оруулалт /Joint venture/	Итали, Испани, Португали, Өмнөд Солонгос
Санхүүгийн үйлчилгээний групп /Finance service group/	Франц, Испани, Бельги, Их Британи, Ирланд

Банкны даатгалын зуучлалын хөгжлийн цаашдын чиг хандлага

Банкны даатгалын зуучлал нь зарим оронд хориглогдсон хэвээр байна. Зарим шинжээчдийн үзэж байгаагаар энэ нь маргаантай асуудал бөгөөд банкны салбарыг санхүүгийн зах зээлд хэт хяналт тавихад хүргэдэг гэж шүүмжилдэг. Гэхдээ дэлхийн чиг хандлага нь банкны хууль тогтоомжийг либералчилж, дотоодын зах зээлийг гадаадын компаниудад нээхэд чиглэж байна.

Дэлхийн зах зээлд Европ дахь банкны даатгалын зуучлалын өсөлтийг 2020 гэхэд Туркт 14,70% , Польшид 15,17% -иар өснө гэж таамаглаж байна. Даатгалын зах зээлд хамгийн өндөр өсөлтийг хадгалж ирсэн нь Европ бөгөөд Баруун Европт даатгалын шимтгэл ДНБ-ний 7.4% -ийг эзэлж байна.


Зураг 5. Европын орнуудын амьдралын даатгалын нэвтрэлт болон зардлын харьцаа



Эх сурвалж: Европын даатгалын хөгжилийн тайлан, 2015 (Insurance, 2016)

Азийн улс орнуудаас сүүлийн жилүүдэд Хятад (19.7%), Филиппин (17.1%) зэрэг бусад банкны даатгалын өсөлт хамгийн өндөр байгаа төдийгүй цаашид ч энэ өсөлт хадгалагдах нөөц байгаа юм.

Зураг 6. Ази номхон далайн орнуудын амьдралын даатгалын нэвтрэлт болон өсөлтийн хувь



Эх сурвалж: World insurance in 2015 (Takeuchi, 2017)

Зураг 6 -д Ази, Номхон далайн бүс нутагт сонгосон 14 улс орнуудын нэвтрэлтийн түвшин болон өсөлтийг харуулав. 2015 онд БНХАУ амьдралын даатгалын хураамжийн орлогоороо дэлхийд (4-рт), Өмнөд Солонгос (7-рт), Тайвань (9-рт), Энэтхэг (10-рт), Хонг Конг (14-рт) тус тус жагсаж байна. Харин өсөлтийн хувиараа Вьетнам (21.2%), Хятад (19.7%), Филиппин (17.1%) улсууд өндөр өсөлттэй байна.

Филиппиний Даатгалын шимтгэл ДНБ-ий 1.7% -ийг эзэлж, борлуулалтын

өсөлт өндөр байгаа нь шинэ компаниудын шимтгэл өссөн нь нөлөөлсөн байна. Хятадад арилжааны даатгалыг хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлсэн бөгөөд нь энэ өсөлтөд ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. Вьетнамын хувьд амьдралын даатгалын зах зээл хадгаламжид чиглэсэн хэвээр байгаа төдийгүй бүтээгдэхүүний өсөлт нь хүүгийн өсөлтөөс гол төлөв хамаардаг. [8]

Харин Тайвань(17.0%), Хонконг(14.0%) зэрэг улсуудын даатгалын хураамжийн орлогын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жин буюу даатгалын нэвтрэлтийн хувь өндөр бөгөөд дэлхийд нэг болон хоёрдугаар байрт орж байна.

Банкны даатгалын зуучлал нь 2014 оноос БНХАУ-д хурдацтай хөгжсөн бөгөөд 108 том банкуудын 54 нь банкны даатгалын зуучлалын үйлчилгээг санал болгож даатгалын бүтээгдэхүүний 30% нь банкны салбараар борлуулагдсан байна.

Өнөөгийн байдлаар банкны болон даатгалын компани улам бүр хамтран үйл ажиллагаа явуулж байгаа төдийгүй ирээдүйд бизнесийн хэтийн төлөвийг сайжруулахын тулд банкны даатгалын зуучлалын бизнес хурдацтай хөгжинө гэж судлаачид таамаглаж байна.

Дүгнэлт

Судалгаанаас дүгнэхэд хөгжингүй улс орнуудын амьдралын даатгалд банкны даатгалын борлуулалтын хувь өндөр байдаг байна.

Европын банкны даатгал нь банкны болон даатгалын байгууллагын нягт хамтын ажиллагаан дээр суурилсан бөгөөд бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хуваарилалт нийлмэл байдалтай, татварын хөнгөлөлт гол зохицуулалт болдог байна. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Европын санхүүгийн зах зээл дэх байгууллагууд зөвхөн өрсөлдөөний хүчин зүйлийн улмаас багасаад зогсохгүй гол банкууд, даатгалын байгууллагууд хоорондоо нэгдэж үйл ажиллагаа явуулах болсон байна.

Мөн Европт Франц, Англи, Австри зэрэг баруун европын орнууд нь банкны сувгийг өргөнөөр ашиглаж байгаа бөгөөд зүүн европын хувьд шинээр хөгжиж байгаа байдалтай байна. Иймд Европ дахь банкны даатгалын зуучлалын зах зээлийн потенциал бүрэн хангагдаагүй тул цаашид хөгжих боломжтой юм.

Манай улсын банкны даатгалын үйлчилгээний салбар хөгжлийн эхэн шатандаа яваа бөгөөд өндөр хөгжилтэй орнуудын жишигт хүрэхэд нилээд хүчин чармайлт шаардагдах юм. Даатгал, банкны салбар хоёр бол санхүүгийн секторт мөр зэрэгцэн хөгжих ёстой салбар. Гэтэл өнөөдөр манай улсын даатгалын зах зээлийн хөгжлийг банкны салбарын хөгжилтэй харьцуулахад нэлээд ялгаатай байна. Харин дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын хувьд энэ

2 зах зээлийн хөгжил нь маш ойрхон түвшинд байдгийн хамгийн наад захын жишээ нь Европын банкуудын хувьд нийт борлуулж буй бүтээгдэхүүний 60 орчим хувь нь банкны бүтээгдэхүүн, үлдэх 40 хувь нь даатгалын бүтээгдэхүүн байдаг. Даатгалын байгууллагуудын хувьд даатгалаа зарж байгаа сувгийн 30 гаруй хувийг банкны даатгалын зуучлал дангаараа эзэлж байгаа бол[4] манай улсад 13% байна. [3]

Банкны даатгалын зуучлалыг өргөжүүлэхийн тулд:

- Банкны даатгалын зуучлалд өнөөгийн байдлаар 8 банк оролцож байгаа нь хангалтгүй ба банкуудыг нэмж татан оролцуулах
- Банкуудаар дамжуулан борлуулж байгаа даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг олшруулах
- Ипотекийн зээлийн даатгалын гэрээг ердийн даатгалын компаниас илүүтэйгээр амьдралын даатгалын компанитай хамтран хийх
- Гадаад орнуудын туршлагаар амьдралын даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг банкуудаар дамжуулж борлуулах
- Даатгалын гэрээ байгуулах үеийн андеррайтингийн үйл ажиллагаанд банкны зуучлагчдыг мэргэшүүлэх
- Банкуудаар дамжуулж зөвхөн даатгалын гэрээ борлуулах бус, банк-даатгалын бусад хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай байна.

Ашигласан материал

- [1] Баярмаа Б, Монгол улсын банкны даатгалын зуучлалын үйл ажиллагааны өнөөгийн байдал цаашдын хандлага, Хэрэглээний стандарт, 2018/02/099, 2018
- [2] Ганбаатар С, “Банкны даатгалын зуучлал голлох үүрэгтэй болно”, УБ, 2015 <https://www.news.mn/?id=191500>.
- [3] Finaccord, Bancassurance Models Around the World, Presentation at the 14th Asia Conference on Bancassurance & Alternative Distribution Channels, pp. 4-5, Jakarta, 2016 http://www.finaccord.com/documents/Presentations/2013/finaccord_presentation_2013_bancassurance-models-around-the-world_jakarta.pdf.
- [4] Elkington W, Bancassurance, Chartered Building Societies Institutions Journal, pp.2-3, 2013.
- [5] Gonulal S, Goulder N, Lester R, Gonulal S, Goulder N, Lester R, Bancassurance, A Valuable Tool for Developing Insurance in Emerging Markets, 2012 <http://elibrary.worldbank.org/docserver/download/6196.pdf?expires=1361777483&id=id&acname>.

- [6] Shah H, Bancassurance Technology Road Ahead, Indian Perspective, Global Journal, Global Journal of Enterprise Information System, Volume-3 Issue-IV, pp-1, 2011
- [7] SCOR, Bancassurance, Mumbai, 2015
- [8] Takeuchi, Y, Bancassurance Operations in the Asia-Pacific Region- FALIA Bancassurance Survey, 2016
- [9] Insurance, European Insurance in Figures,2016 <https://www.insuranceeurope.eu/sites/default/files/attachments/European%20Insurance%20in%20Figures%20-%202015%20data.pdf>.
- [10] Investopedia, Bancassurance, 2018
- [11] <https://www.investopedia.com/terms/b/bancassurance.asp>.
- [12] Leitao J, Bancassurance, Mumbai, 2014
- [13] <https://www.slideshare.net/amolcbz/a-study-on-bancassurance-final-year-proj>.
- [14] <https://www.slideshare.net/jesmolleitao/bancassurance-29728085>.
- [15] <https://www.slideshare.net/YasutakaTakeuchi/falia-bancassurance-survey-2016>.